



“ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНД ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.

АГУУЛГА

<p>Тайланг бэлтгэсэн: Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p> <p>Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа</p> <p>Аудитор Б.Уранбилэг Т.Мөнхтогтох</p> <p>2018 оны 09 сарын 24</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70523020 дугаарын утас 70522734 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Дорноговь аймаг Сайншанд сумын 3-р баг Орон нутгийн өмчийн 3 дугаар байр</p>	<p>Товчилсон үгийн тайлбар 2 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3</p> <p>Бүлэг 1: Мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, мэдээллийн санг үр дүнтэй ашиглахад анхаарч ажиллах шаардлагатай байна.</p> <p>1.1. Халамжийн үйлчилгээний чиглэлээр мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, арга зүйгээр хангах, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй байна.</p> <p>1.2. Өрхийн мэдээллийг санг үнэн зөв бүрдүүлж үр нөлөөтэй ашиглах хэрэгтэй байна.</p> <p>Бүлэг 2: Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.</p> <p>2.1. Халамжийн үйлчилгээний зардлыг бодитой төлөвлөх шаардлагатай байна.</p> <p>2.2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, халамжийн болон хөгжлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулах хэрэгтэй байна.</p> <p>Бүлэг 3: Хяналтаар өгөгдсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.</p> <p>3.1. Халамжийн сангийн үйл ажиллагаанд хийгдсэн хөндлөнгийн болон дотоод хяналтын зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.</p> <p>3.2. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.</p> <p>Дүгнэлт..... 28 Зөвлөмж 29 Холбогдох байгууллагын санал:..... 30</p> <p>Аймгийн Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын тушаал 31</p>
--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДЗ	Амьжиргаа дэмжих зөвлөл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НХТ	Нийгмийн халамжийн тухай
НХҮ	Нийгмийн халамжийн үйлчилгээ
НХХ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөр
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНОТ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн
ӨМНС	Өрхийн мэдээллийн нэгдсэн сан
СИТХ	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАХНХ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХБ	Хөгжлийн бэрхшээлтэй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХЭБ	Хүнсний эрхийн бичиг
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭХАХМ	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
ЭМТ	Эрүүл мэндийн төв

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/106 дугаар тушаалаар батлагдсан 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Аудитын зорилт:

Нийгмийн халамжийн тухай хууль, журмын хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Нийгмийн халамж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх тодорхой зорилтууд байгаа эсэх;
- Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, журам зааврыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэх;
- Үйлчилгээний чанар, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 14 сумын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийн 2017 он болон 2018 оны эхний хагас жилийн байдлаар хяналт, шалгалтыг хэрэгжүүллээ.

Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага, хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, хамрах хүрээ, арга хэлбэр, хүрсэн үр дүн үндсэн үзүүлэлт, шилдэг практик, арга туршлагатай харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль;
- Нийгмийн халамжийн тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль;

- Засгийн газрын 2012 оны 136 дугаар тогтоол /2014 оны 343 дугаар тогтоол, 2017 оны 340 дүгээр тогтоол, 2018 96 дугаар тогтоол/, /Тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай/;
- Засгийн газрын 2012 оны 153 дугаар тогтоол /Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнийг тогтоох тухай/;
- Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол /Журам батлах тухай/;
- Засгийн газрын 2013 оны 19 дүгээр тогтоол /Хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай/;
- Засгийн газрын 2015 оны 11 дүгээр тогтоол /Дүрэм шинэчлэн батлах тухай/;
- Засгийн газрын 2016 оны 293 дугаар тогтоол, 2018 оны 17 дугаар тогтоол /Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай/;
- Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын даргын 2014 оны 66 дугаар тушаал /Аргачлал батлах тухай/;
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаал /Хүнсний эрхийн бичиг/;
- Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн эмхэтгэл 2015 он;
- Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн гарын авлага 2015 он.

Аудит хийж гүйцэтгэсэн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Лүндэгмаа гүйцэтгэж, аудитор Б.Уранбилэг, Т.Мөнхтогтох нар 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 09 дүгээр сарын 24-ийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 1

Мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, мэдээллийн санг
үр дүнтэй ашиглахад анхаарч ажиллах
шаардлагатай байна.


1.1 Халамжийн үйлчилгээний чиглэлээр мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, арга зүйгээр хангах, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй байна.

1.1.1 Нийгмийн халамжийн үйл ажиллагааг хариуцсан мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр, халамжийн тэтгэмж, халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн төрлөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь үйл ажиллагааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Захиргаа, хяналтын хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, Нийгмийн халамжийн хэлтэс, Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар ажилласан байна. Үүнээс нийгмийн халамжийн хэлтсийн бүтцийг бүдүүвч №1-д харуулбал:

Бүдүүвч №1



Сайншанд, Замын-Үүд суманд халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус 2, Замын-Үүд суманд хөдөлмөр эрхлэлт хариуцсан 1 мэргэжилтэн, бусад суманд халамжийн сан, хөдөлмөр эрхлэлтийн сангуудыг 1 мэргэжилтэн хариуцан 2 хэлтсийн харьяанд үйл ажиллагаа явуулж байна.

Хөдөө орон нутагт ажиллах мэргэжилтэй боловсон хүчин дутмаг, сумдад халамж, хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтний орон тоо нэг байдгаас шалтгаалж ажилтан шалгаруулах, мөн ажлын байрны тодорхойлолтод *нийгмийн ажилтан, эдийн засагч, нягтлан бодогч, эрх зүйч, багш, харилцааны ажилтан, эмч, инженер* гэж заасан байна.

Үүнээс шалтгаалж Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1¹ дэх заалтын хэрэгжилт хангалтгүй, нийгмийн халамжийн чиглэлээр мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байна. Тухайлбал: Гадаад харилцааны ажилтан, аялал жуулчлалын эдийн засгийн удирдлага, таваар судлал, материал судлал химийн технологи, англи хэлний багш орчуулагч, эрх зүйч, нягтлан бодогч гэх мэт.

Ажилтнуудын ажлын мэргэжил, ажилласан хугацааг судалж үзэхэд 4 хүн буюу 20 хувь нь нийгмийн ажилтан мэргэжилтэй, 70 хувь нь тухайн байгууллагад 1-5 жил ажилласан ажлын туршлагатай байна.

Ажлын туршлага, хариуцлага, мэргэжлийн ур чадвар сул байгаагаас Нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмжийг програмд давхар бүртгэх, шилжсэн тухай бүр хасалт хийгээгүй зөрчил гаргасан байна. Тухайлбал: 2017 онд 37 иргэнд 3.8 сая төгрөг, 2018 онд 14 иргэнд 2.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг илүү олгож, буцаан төлүүлсэн байна.

Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн ажилтнуудад /2017 онд 10, 2018 онд 2 мэргэжилтэнд/ сахилгын шийтгэл ногдуулсан байв.

Эдгээрээс харахад мэргэжилтнүүдийг арга зүйгээр хангаж, мэргэжлийн чиглэлээр танхимын болон ажлын байрны сургалтад хамруулж чадваржуулах хэрэгтэй байна.

1.1.2 Нийгмийн халамжийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж байгаа ч дэвшүүлсэн зорилтын хүрээнд шинэлэг ажил санаачлан зохион байгуулаагүй байна.

ХХҮЕГ нь Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээний талаар төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломж бүрдүүлэх бодлого баримтлан ажиллажээ.

Харин орон нутагт Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэх, халамж, асрамжийн шинэ үйлчилгээ менежментийг нэвтрүүлэх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор үйлчилгээг чанартай хүргэх гэсэн стратегийн зорилтыг дэвшүүлжээ.

¹ *Нийгмийн ажилтны мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, ажил, үйлчилгээ явуулах эрх авсан иргэнийг нийгмийн ажилтнаар ажиллуулна.*

Нийгмийн халамжийн тухай хуулийн 28.8-д заасан мэдээллийн сан бүрдүүлэх, нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх, амьжиргаагаа дээшлүүлэх чадавхтай болоход нь зөвлөн туслах, сургалт зохион байгуулах, эрүүл мэнд, боловсролыг дэмжих нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай зуучилж өгөх зэрэг үүргээ мэргэжилтнүүд хэрэгжүүлэн ажилласан байна.

Үүнд:

- Сумдын мэргэжилтнүүд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн судалгааг төрөл тус бүрээр сүүлийн 5 жилийн байдлаар гарган мэдээллийн сан үүсгэсэн байна. /График №1-2/

График №1





График №2



- Мэргэжилтнүүд өрхийн нийгмийн үзүүлэлтийн судалгааг гарган жил бүр хөгжүүлэх зорилтот өрхийг сонгон түүнд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна. Мөн суманд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудтай хамтран зорилтот бүлгийн иргэд, хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй иргэдийг ажлын байранд зуучилж ажиллажээ. Тухайлбал: 2018 онд Айраг суманд 20 өрхийг хөгжүүлэхээр сонгосон ба үүнээс 8 иргэнийг, хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 11 иргэнийг ажилд зуучилсан байна. Хөвсгөл суманд 10 өрх сонгогдсон ба үүнээс 7 иргэн байнгын болон түр ажлын байртай болсон байна.
- Ажилгүй иргэдэд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар иргэдэд сургалт явуулсан байна.

Эрүүл мэндийг дэмжих нийгмийн хөгжлийн үйлчилгээг зорилтот өрх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн бүхий өрхөд зуучлан ажилласан байна. Тухайлбал:

- Айраг сумын мэргэжилтэн ЭМТ-тэй хамтран нарийн мэргэжлийн эмч нарын төлбөргүй оношилгоонд 7 иргэнийг;
- Алтанширээ сумын мэргэжилтэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, элэгний В, С вирусийн шинжилгээнд ЭМТ-тэй хамтран ахмад настан, ХБИ, зорилтот өрхөөр сонгогдсон өрхийн 15 иргэнийг;
- Улаанбадрах сумын мэргэжилтэн улирал бүр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт зорилтот бүлгийн иргэдийг;
- Хатанбулаг сумын мэргэжилтэн улирал бүр ЭМТ-тэй хамтран байнгын асаргаатай иргэдийг;
- Хөвсгөл сумын мэргэжилтэн сар бүр ЭМТ-тэй хамтран ХБИ-ийг;
- Сайншанд сумын Зүүнбаян багийн мэргэжилтэн эрүүл мэндийн чиглэлээр байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ахмад, ХБИ-тэй өрх тус бүрээр улиралд нэг удаа Сум дундын эмнэлгийн их эмчтэй хамтран улирал бүр гэрээр үзлэг хийн хөнгөлөлттэй эм тарианд хамруулан ажилласан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон сургууль, цэцэрлэг завсардсан хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулсан байна.

Боловсролыг дэмжих үйлчилгээний хүрээнд:

- *Мандах сумын мэргэжилтэн аймгийн Нутгийн зөвлөлөөс “Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн нэг хүүхдийг их, дээд сургуульд суралцуулах тэтгэлэгт хөтөлбөр” зарласны дагуу зорилтот өрхийн 2 оюутны материалыг хүргүүлж 1 оюутныг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулж ажилласан байна.*

Нийгмийн халамжийн тухай хуульд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд амьдрах ухаан, зөв дадал эзэмшүүлэх сургалтад хамруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засах, асрамжлан байрлуулах зэрэг 9 төрлийн үйлчилгээнд зорилтод иргэдийг хамруулахаар заажээ. Үүний дагуу ОНОТ халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор тогтмол үйл ажиллагаа явуулдаг 4 ТББ-тай сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан хэрэгжүүлжээ. Үүнд 2017 онд 359 ахмад настан иргэн, 128 ХБИ хамрагдсан байна. Энэ нь өмнөх оноос 293 иргэнээр нэмэгдсэн байна.

Мөн хуулийн 18.1.9-д заасан үйлчилгээг хүргэхээр ХЭДС-аас халамжийн үйлчилгээнд хамрагддаг хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асрамжилдаг 2 эцэг эх гэсэн 7 иргэнийг шинэ ажлын байраар хангах зорилгоор 21.0 сая төгрөгийг санхүүжилтийг олгосон байна. Харин амьдрах ухаан, зөв дадал эзэмшүүлэх сургалт асрамжлан байрлуулах зэрэг чиглэлээр шаардлага, нөхцөл хангах тогтвортой үйлчилгээ явуулдаг иргэн, ААНБ байдаггүй байна.

Хууль журмын дагуу өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байгаа боловч зорилтын дагуу шинэ төрлийн үйлчилгээ турших, халамжаас хасагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээний талаар санаачлан хэрэгжүүлсэн ажил тодорхойгүй, зардлыг санхүүжүүлэх хөрөнгө мөнгийг тооцож шийдвэрлүүлээгүй байна.

1.1.3 Сумдын амьжиргаа дэмжих зөвлөлийг хууль, эрх зүйн сургалт, арга зүйн удирдлагаар хангах шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд “... амьжиргаа дэмжих зөвлөл нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба сумын Засаг даргын санал болгосноор тухайн сумын ИТХ-аар хэлэлцэн батална” гэж заасан байна.

Үүний дагуу аймгийн 14 суманд 7 хүний бүрэлдэхүүнтэй Амьжиргаа дэмжих зөвлөл үйл ажиллагаа явуулж байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сумдын ИТХ-аар хэлэлцүүлэн баталж нарийн бичгийн даргаар тухайн сумын нийгмийн ажилтаныг томилсон байна.

Амьжиргаа дэмжих зөвлөл нь Нийгмийн халамжийн тухай хуулинд заасан тэтгэвэр тэтгэмж, халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй өрх, иргэдээс ирүүлсэн хүсэлт, судалгаанд үндэслэн баримт бичиг, амьдралын нөхцөлийг судлан, нийгмийн халамжийн холбогдох үйлчилгээнд хамрагдах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэх үндсэн үүрэгтэй байдаг. Сумдын АДЗ-ийн хурлын тэмдэглэлээс харахад хүн ам цөөтэй сумдын зөвлөлийн гишүүд нь халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэн, өрхөө сайн мэддэг хэдий ч нөхцөл байдлын үнэлгээг хэрхэн хийж байгаа нь тодорхойгүй байна. Сайншанд, Замын-Үүд сум олон хүн амтай ба өрх, хүн бүрийг танихгүй тул харьяалагдах багийн Засаг дарга, хэсгийн ахлагчдыг зөвлөлийн хуралд оролцуулж, мэдээлэл авдаг, зөвлөлийн гишүүд зарим айл, өрхөөр явж нөхцөл байдлын үнэлгээ хийж хэлэлцсэн байна.

Харин Замын-Үүд сумын амжиргаа дэмжих зөвлөл айл, өрхөөр нөхцөл байдлын үнэлгээ хийсэн эсэх нь тодорхойгүй, зөвлөлийн нарийн бичгийн даргаас ерөнхий мэдээлэл авснаар асуудлыг хэлэлцсэн байна.

АДЗ-ийн дүрэмд зөвлөлийн гишүүдэд улиралд нэг удаа урамшуулал олгоно гэж заасан байна. Үүний дагуу аймгийн хэмжээнд 2017 онд 14.6 сая төгрөг, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 2.4 сая төгрөгийн урамшуулал олгожээ.

Мөн АДЗ нь үйл ажиллагааны тайлангаа улирал бүр нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад ирүүлэхээр журамлагдсан байдаг. Тайланд хурлын ирц, оролцоо, мөнгөн тусламжид хамрагдах өрх, иргэний амьдралын нөхцлийг судлах ажилд биечлэн оролцсон байдал зэргийг тодорхой тусгах байтал зөвхөн ирц, хэлэлцсэн асуудлаас өөр тодорхой зүйл тусгаагүй байхад урамшууллыг тооцож олгосон байна.

НХХ-ийн сайдын 2012 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Амьжиргаа дэмжих зөвлөлийн дүрэм”-ийн 5.4-т “... аймгийн нийгмийн халамжийн байгууллага нь АДЗ-ийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, зөвлөлийн гишүүдийг сургах, үйл ажиллагаатай нь танилцах ажлыг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Байгууллагын даргын 2017-2018 оны үр дүнгийн гэрээнд АДЗ-ийн үйл ажиллагаанд сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх ажил тусгагдаагүй, захиргаа хяналтын хэлтсийн 2018 оны эрсдэл, хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасан боловч одоогоор хэрэгжүүлсэн тодорхой ажил байхгүй байна.

Сайншанд сумын халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн 2017 онд 4 удаа солигдсоноос зөвлөлийн үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй, мэргэжлийн хувьд шаардлага хангахгүй зэрэг хүндрэл үүссэн байна. Бусад сумдын АДЗ-ийн гишүүд халамжийн үйлчилгээний талаарх мэдлэг арга зүй дутмаг, зөвлөлийн нарийн бичгийн даргаас ямар хуулийн заалттай байдаг, ямар арга хэмжээ авах зэргийг хурлын үеэр асууж шийдвэр гаргаж байна.

Иймд сумдын АДЗ-д нийгмийн халамжийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн талаар сургалт, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, улирлын тайланг заасан хугацаанд ирүүлэхэд анхаарч, олгох урамшууллыг гишүүдийн оролцоонд үндэслэн тооцох нь зүйтэй байна.

1.2 Өрхийн мэдээллийг санг үнэн зөв бүрдүүлж үр нөлөөтэй ашиглах хэрэгтэй байна.


1.2.1 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын мэдээлэл, өрхийн мэдээллийн санг бүрдүүлж ажилласан байна.

ХХҮГ-т халамжийн сангийн мэдээллийн онлайн систем, өрхийн мэдээллийн санг ашиглаж нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.


Нийгмийн халамж, үйлчилгээний мэдээллийн онлайн системд нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдагсдын мэдээлэл байдаг байна.

Онлайн www.wais.hudulmur-halamj.gov.mn хаягаар олголт хариуцсан мэргэжилтэн, нягтлан бодогч нэвтэрч мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих, тэтгэвэр тэтгэмжийн олголтын жагсаалт гаргаж банкинд хүргүүлэх, сумдын халамжийн мэргэжилтэн шинээр тэтгэмж авах иргэнийг нэмэх, нас барсан иргэнийг хасах, мөн шилжилт хөдөлгөөнөөр нэмэгдсэн, хасагдсан мэдээллийг тухай бүр оруулах ажлуудыг гүйцэтгэдэг байна. /Зураг №1-2/

Зураг №1



Зураг №2



Засгийн газраас 2013 онд “Улсын хэмжээнд судалгаа хийх тухай” 269 дүгээр тогтоол гарч Дорноговь аймагт амьжиргааны түвшин тодорхойлох 16543 өрхийн тоо өгөгдсөний дагуу аймгийн нийт өрхийн 85.2 хувь буюу 15821 өрхийг хамруулж, 2017 онд нийт өрхийн 58.5 хувь буюу 12194 өрхийг хамруулж мэдээллийн санд оруулсан байна. /Хүснэгт №1/

ӨМНС-д оруулсан өрхийн тоо

Хүснэгт №1

Д/д	Он	Аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан нийт өрхийн тоо	Асуулга авах өрхийн тоо	Мэдээллийн санд оруулсан өрхийн тоо	Нийт өрхөд эзлэх хувийн жин
1	2013	18554	16543	15821	85.2
2	2017	20844	12836	12194	58.5

Өрхийн амьжиргааны нөхцөл байдлыг 11 үзүүлэлтээр судалж мэдээлэл цуглуулан олон улсад хэрэглэгддэг тооцооллын арга зүйг ашиглаж амьжиргааны түвшин тодорхойлдог байна. Тухайлбал:

- Өрхийн үндсэн мэдээлэл;
- Өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал;
- Өрхийн орлогын эх үүсвэр;
- Гэр бүлийн орлогын зарцуулалт;
- Гэр бүлийн гишүүдээс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг эсэх;
- Гэр бүлийн орон байрны нөхцөл;
- Зан төлөв /зуршил/;
- Өрхийн гишүүдийн боловсролын байдал;
- Өрхийн амьдрах орчны хүртээмж;
- Өрхийн гишүүдэд зориулсан цаашид хамтран шийдвэрлэх шаардлагатай асуудлууд;
- Өрхийн шилжилт хөдөлгөөн.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээр Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд зорилтот өрхийн гишүүн-иргэнд дараах үйлчилгээг үзүүлдэг байна.

- Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ;
- Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх иргэн;
- Төлбөрийн чадваргүй яллагдагчид үнэгүй өмгөөллийн үйлчилгээ;
- Хорих ангиас суллагдсан иргэнд гэр олгох;
- 0-18 насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон иргэн;
- Хүүхдийн мөнгө.

2017 онд судалгаанд хамрагдаж чадаагүй болон өрхийн амьжиргааны түвшин тогтоосон үзүүлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, дахин судалгаанд орох хүсэлтэй 1173 өрх өргөдөл гаргасан байна. Хүсэлт гаргасан иргэдийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд оруулж шинэчлэх, судалгаанд хамруулж босго оноог бодуулснаар одоогийн байдлаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд нийт 13776 өрхийн мэдээлэл шивэгдсэн байна.

1.2.2 Өрхийн мэдээллийн санг журмын дагуу холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ашиглах, судалгаа, мэдээллээ солилцох зэргээр үр нөлөөтэй ашиглах хэрэгтэй байна.

Халамжийн сангийн мэдээллийн онлайн системийг 2016 оны 04 дүгээр сараас үйл ажиллагаандаа хэрэглэж ирсэн бөгөөд онлайн системийг ашигласнаар тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийн давхардал /харьяалал/ үүсдэггүй, ямар хүн мэдээлэл оруулсан нь харагддаг зэрэг давуу тал бий болсон байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс сар бүр нас барсан иргэдийн жагсаалт ирүүлдэг ба тус жагсаалтад халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг иргэд байгаа эсэхийг тулгаж онлайн системд хасалт хийжээ. Аудитын явцад 2017 оны 5, 10, 11 сард нас барсан иргэдийн нэрсийн жагсаалтыг тэтгэвэр, тэтгэмж авч буй иргэдийн нэртэй харьцуулж давхардал, илүү олголт байгаа эсэхийг шалгахад зөрүү гараагүй болно.

Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”-ын дагуу өрхийн мэдээллийн санг бүрдүүлэхдээ өрхийн мэдээллийг статистик, улсын бүртгэл, нийгмийн даатгалын байгууллагуудтай тулгаж баталгаажуулсан байна. Харин эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрх бүхий бусад байгууллагуудтай мэдээллийг тулгадаггүй байна. Мэдээлэл үнэ төлбөргүй солилцох ажлын хүрээнд тодорхой ажил хийгдээгүй байна.

1.2.3 Өрхийн мэдээллийн сангийн судалгааны дүнд зарим иргэд сэтгэл дундуур байна.

ХХҮГ нь 2018 онд төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлэх, мэдээлэл өгөх зорилгоор сар бүрийн 2 дахь 7 хоногийн 2 дахь өдрийн 2 цагт “Хөдөлмөр- халамж 222” өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан байна. Сайншанд сумын 1, 2, 3, 4, 7 дугаар багийн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн талаар мэдээлэл хүргэсэн байна.


Сэтгэлд нийцсэн халамжийн үйлчилгээний асуудлын хүрээнд ямар чиглэлээр иргэдээс өргөдөл ирүүлснийг судлахад 2017 оны 1-7 сар хүртэлх хугацаанд өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн байхгүй байсан байна. Тэтгэмжтэй холбоотой иргэдийн өргөдлийг холбогдох мэргэжилтнүүдэд цохож, тухайн мэргэжилтэн уг өргөдлийг шийдвэрлэж холбогдох баримтаар архивын нэгж болгон үүсгэдэг гэсэн тайлбар өгсөн хэдий ч ямар асуудлаар хэдэн өргөдөл ирснийг аудитаар нотолж чадаагүй болно.

Харин 2017 оны 8-12 сар хүртэлх хугацаанд ирсэн өргөдөл, гомдлыг бүртгэж архивын нэгж үүсгэсэн ба асрамжийн газарт орох, хүнсний талонд хамрагдах, өрхийн мэдээллийн сантай холбоотой болон бусад асуудлаар ирсэн өргөдлийг шийдвэрлэсэн байна. Тухайлбал: Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаж чадаагүй болон өрхийн амьжиргааны түвшний үзүүлэлтээ хүлээн зөвшөөрөхгүй дахин судалгаанд орох өргөдөл 1173 өрхөөс гаргасан байна.


Аудитаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны 6 үзүүлэлт бүхий асуулга бэлтгэж Сайншанд сумын төвийн 6 багт ажиллалаа. Санал асуулгад нийт 144 хүн хамрагдсанаас 26-35 настай иргэд 42%, 36-49 настай иргэд 28%, 50-аас дээш настай иргэд 23%-ийг эзэлж байна.

Дүнг нэтгэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйлчилгээ таныг чирэгдүүлж байсан уу? гэсэн асуултад 86 хувь нь үгүй,
- Мэргэжилтнүүд ёс зүйн харилцааны доголдол гаргадаг уу? гэсэн асуултад 57 хувь нь үгүй,
- Нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгтээ хүрч чадаж байна уу? гэсэн асуултад 63 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.



Асуулгын дүнг график дүрслэлээр харуулав.



Хэрэв чирэгдүүлдэг бол ямар шатанд хүндрэлтэй байна вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулт өгсөн байна.

- Ажлын цагаар мэргэжилтэн нь эзгүй байдаг.
- Хүмүүс нь ашиг сонирхлын дагуу үйлчилдэг.
- Халамжийн мөнгө сарын сүүлээр ирдэг ч заримд нь хүрэхгүй үе байдаг.
- 4 хөлтэй тэрэг түрдэг хүнийг халамжаас хасдаг.
- Хүнд суртал ихтэй нааш цааш их гүйлгэдэг.
- Бүх шатанд хүндрэлтэй.
- Нам солигдохын үеэр.

Тус асуулгын санал гомдлын хэсэгт: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний түвшин сайн, хүмүүст хүрч чаддаг, зөв өрх айлд хүнсний талоноо өгч чаддаг, сэтгэл хангалуун явдаг, үйлчилгээ сайтай харилцааны соёлтой гэсэн байхад зарим иргэд үйлчилгээндээ анхаарах дараах асуудлаар санал өгсөн байна.

- Амьжиргааны түвшин тогтоох судалгаанд өрхийн орлого асуудаггүй, бодит судалгаа гаргаагүйгээс хүнсний талоныг зарим бололцоотой айл өрх авдаг, шаардлагатай айл өрх авч чаддаггүй, хүнсний талонд хамрагдах өрхийг зөв сонгох хэрэгтэй.
- Халамжийн мөнгийг хэт хавтгайруулан олгож байгаа нь иргэдийг ажил хийх хүсэлгүй болгож байна.
- Хүнсний талоны барааг хүрэлцээтэй олгож баймаар юм.
- Хүүхдийн 20,000 төгрөг олгогдохгүй байна.
- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын үйлчилгээг сайжруулж олон шат дамжлагагүй болгох, мэргэжилтнүүдийн ёс суртахууныг сайжруулах, харьцааны соёлтой, иргэдэд ойр ажиллах
- Хүнсний дэлгүүрт хяналт тавих. Хүнсний дэмжлэг үзүүлдэг зарим дэлгүүрүүд архи өгдөг.
- Банк бус санхүүгийн байгууллагаас судалгаа авах
- Амьжиргаа дэмжих зөвлөлийн дарга, гишүүд амьдрал мэддэг хүмүүс байх.

**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
САНД ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

БҮЛЭГ 2

**Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт,
зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах
шаардлагатай байна.**

2.1. Халамжийн үйлчилгээний зардлыг бодитой төлөвлөх шаардлагатай байна.

2.1.1 Зарим зардлуудыг судалгаа болон бодит гүйцэтгэлд үндэслэн тооцоогүй байна.

Нийгмийн халамжийн сангийн төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” болон эрх бүхий байгууллагаас тогтоосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээний төрөл, хэмжээг баримталж нэр төрөл тус бүрээр 2015 оны гүйцэтгэл, 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг харгалзан тооцсон байна.

Орон нутгийн халамжийн сангийн 2017 оны төсвийн төслийг 5,052.5 сая төгрөгөөр /хүний тоо-12906/ боловсруулан хүргүүлсэн ба Сангийн яамнаас 4,845.1 сая төгрөг /хүний тоо-11819/ буюу 207.5 сая төгрөгөөр бууруулж хянаж ирүүлсэн байв. Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын хурлаар 2017 онд орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн сангийн санхүүжигдэх дүнг 4,845.1 сая төгрөгөөр хэлэлцэж төсөв баталсан байна. /Хүснэгт №2/

2017 оны төсвийн гүйцэтгэл /сая.төг/

Хүснэгт №2

Д/д	Тэтгэмжийн төрөл	Анхны төсөв		Тодотгол		Гүйцэтгэл	
		хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	-	6.7	-	6.7	-	6.7
2	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	-	19.9	-	19.9	-	19.9
3	Нийгмийн халамжийн тэтгэвэр	1244	1,861.0	2131	1,981.5	1440	2,131.6
4	Жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж	1750	840.0	2286	857.5	2981	707.5
5	Нөхцөлт мөнгөн тусламж	1012	703.3	1652	741.2	1278	741.2
6	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	90	20.0	90	20.0	283	20.0
7	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	1102	559.5	1539	600.3	1292	600.3
8	Хоол тэжээлийн тусламж үйлчилгээ	2480	299.8	8072	379.1	1729	379.1
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ	1367	296.0	1443	303.4	793	303.4
10	Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	2774	238.9	2903	254.0	1458	253.9
Нийт дүн		11819	4,845.1	20116	5,163.6	11254	5,163.6

2016 оны эцэст хувь хүмүүст 239.3 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийн, дэлгүүрүүдэд 79.3 сая төгрөгийн нийт 318.6 сая төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд энэхүү өрийг барагдуулахын тулд 2017 оны 05 дугаар сард ИТХ-аар төсөвт нэмэлт оруулж 5,163.6 сая төгрөгийн тодотгол хийлгэсэн байна.

Гэтэл хоол тэжээлийн тусламжийн үйлчилгээний зардалд нэмж тодотгуулсан 79.3 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн зардалд шилжүүлэх хүсэлт гаргаж зарцуулсан байна.

Халамжийн сангийн 2018 оны төсвийн төслийн саналыг 5,313.6 сая төгрөгөөр боловсруулан хүргүүлсэн ба аймгийн ИТХ-аас 5,483.1 сая төгрөгийн төсөв баталсан байна. /Хүснэгт №3/

2018 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл /сая. төг/

Хүснэгт №3

Д/д	Тэтгэмжийн төрөл	Төсвийн төсөл		Батлагдсан төсөв		Хагас жилийн гүйцэтгэл	
		хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн	хүний тоо	мөнгөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	-	6.7	-	6.7	-	2.7
2	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	-	19.9	-	19.9	-	2.4
3	Нийгмийн халамжийн тэтгэвэр	1224	2,086.5	1224	2,393.3	1325	1,158.5
4	Жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж	1790	859.2	1790	358.0	1125	134.0
5	Нөхцөлт мөнгөн тусламж	984	755.7	984	832.8	1036	395.4
6	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	120	22.6	120	20.0	-	-
7	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	1173	551.4	1173	551.4	951	323.0
8	Хоол тэжээлийн тусламж үйлчилгээ	3090	368.9	3090	690.0	2896	173.8
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ	1570	327.7	1570	296.0	182	35.2
10	Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	4906	315.0	4906	315.0	3499	107.4
Нийт дүн		14857	5,313.6	14857	5,483.1	11014	2,332.4

2018 оны төсвийн төсөл, батлагдсан төсвийг харьцуулахад дараах байдалтай байна:

Нийгмийн халамжийн тэтгэвэр 306.8 сая төгрөгөөр, нөхцөлт мөнгөн тусламж 77.1 сая төгрөгөөр, хоол тэжээлийн тусламж үйлчилгээ 321.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмж 501.2 сая төгрөгөөр, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 2.6 сая төгрөгөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний зардлыг 31.7 сая төгрөгөөр тус тус бууруулж төсвийн төслийг нийт 169.5 сая төгрөгөөр нэмсэн шалтгаан нь Сангийн сайдаас ирүүлсэн “2018 оны төсөв хүргүүлэх тухай” албан бичгээр ирүүлсэн удирдамжийг үндэслэжээ.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зардал 2018 оны эхний хагас жилийн бодит гүйцэтгэл болон сүүлийн хагас жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн нийт дүн 455.8 сая төгрөг байгаа бөгөөд судалгааны үр дүнгээр цаашид нэмэгдэх магадлалтай зардлыг 121.4 сая төгрөгөөр тооцоход 577.1 сая төгрөгийн зардал гарах магадлал байна. Батлагдсан төсвөөс энэхүү дүнг хасахад хүнс тэжээлийн дэмжлэгийн зардалд 112.9 сая төгрөгөөр хэмнэлт үүсэхээр байна. */Халамжийн сангийн нягтлан бодогчтой тооцооллыг тулгав/*

Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээнд 2016 оноос өрх иргэдийг ихээр хамруулж байсан бөгөөд санхүүжилтийг сар сард нь бүрэн өгч чадахгүй байдал үүссэн байна. Иймд энэ үйлчилгээнд хамрагддаг өрх, иргэдийг АДЗ-өөр дахин хэлэлцүүлж зайлшгүй хамрагдах шаардлагатай өрхүүдийг сонгох ажил зохион байгуулснаар 2016 оны эцэст аймгийн хэмжээнд 599 өрхөд уг үйлчилгээг үзүүлж байсан бол 2017 оны 4 сарын байдлаар 294 өрх болж буурчээ.

Мөн 2017 онд жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 150.0 сая төгрөгөөр хэмнэгдэж 707.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 2018 онд 859.2 сая төгрөгөөр төсөвлөсөн, хурлаас үүнийг 501.2 сая төгрөгөөр бууруулж 358.0 сая төгрөгөөр төсөв баталсан байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар тус зардлын гүйцэтгэл 134.0 сая төгрөг байна.

Сангийн яам, ИТХ-аас зардлын бүлгийн дүнгээр хянаж, баталдаг тул бүлэг доторх зардлын зүйлийн нэр төрлүүдийн аль зардлаас хасаж аль зардлыг нэмэгдүүлсэн нь тодорхойгүй байдаг байна.

Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу бүртгэж тайлагнах ёстой. Гэтэл батлагдсан төсвийг зардлын зүйлээр хуваарилан дүнг гаргаж төсвөө хянадаггүй байна. Тухайлбал: Ахмад настанд олгох хөнгөлөлт тусламжийн 11 төрөл тус бүрд батлагдсан төсвийг хуваарилан хянаагүй байв.

Иймд нэг удаа олгох хөнгөлөлт, тусламжийн онцлог байдлыг харгалзан /ахмад настан, ХБИ-д олгох амралт, сувиллын болон түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэх гэх мэт/ төсвөө хуваарилж, хянах шаардлагатай байна.

Эдгээр байдлаас харахад зардлуудыг судалгаа болон бодит гүйцэтгэлд үндэслэн тооцоогүй, нөхцөл байдлыг зөв үнэлж төлөвлөөгүй байна.

2.1.2 Нийгмийн халамжийн үйлчилгээний зардлын төсөв бодитой хийгдээгүйгээс бүлэг хооронд шилжүүлж тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд “Халамжийн сангийн орлого”-ыг дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна.

- Улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- Сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү;
- Олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж;
- Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж;
- Бусад эх үүсвэр.

Орон нутгийн төсвөөс 2017 онд нийгмийн халамжийн санд 5,163.6 сая төгрөгийн санхүүжилт, 9.8 сая төгрөгийн банкны хүүгийн орлого тус тус орсон ба олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив тусламж, аж ахуйн нэгж байгууллага иргэдээс өгсөн хандив тусламжийн орлого байхгүй байна.

Урсгал зардалд 5,162.9 сая төгрөг зарцуулж, 10.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Төвлөрүүлсэн мөнгө нь нийгмийн халамжийн тэтгэврийн хэмнэлт 0.7 сая төгрөг, банкны хүүгийн 9.8 сая төгрөг байна.

Нийгмийн халамжийн сангийн 2017 оны батлагдсан орон нутгийн төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг аймгийн орон нутгийн төсвөөс бүрэн олгож, 2017 онд өр, авлагагүй гарсан байна.

2018 оны хагас жилийн байдлаар Санхүүгийн тайлангаар 91.6 сая төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд энэ нь санхүүжилтийн дутуугаас биш харин иргэд халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг арилжааны банкнаас аваагүйгээс үүссэн байна.

2.2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, халамжийн болон хөгжлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтаа сайжруулах хэрэгтэй байна.

2.2.1 Нийгмийн халамжийн тэтгэврийг хуулийн дагуу олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэнд 5 төрлийн тэтгэвэр олгосон байна. 2017 онд 1440 хүнд 2,131.6 төгрөг, 2018 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 1325 хүнд 1,158.5 сая төгрөг олгожээ.

Аудитаар тэтгэвэр авсан 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй иргэдийн нэрсийг нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн нэрстэй харьцуулж давхардал, илүү олголт байгаа эсэхэд тулгалт хийхэд зөрүү гараагүй болно.

2017 онд тэтгэвэр авч байсан 62 иргэнээс 4 иргэн нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас тэтгэвэр авах эрх үүсэж шилжсэн байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 58 иргэн халамжийн тэтгэвэр авсан байна.

2.2.2 Нийгмийн халамжийн тэтгэмжийн давхардал байгаа эсэхэд тавих хяналтаа сайжруулах хэрэгтэй байна.

Нөхцөлт мөнгөн тэтгэмжид 2017 онд 1652 иргэнд 741.2 сая төгрөг, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 1036 иргэнд 395.4 сая төгрөг олгосон байна. Тухайлбал: 2018 оны хагас жилээр эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай иргэнийг асарч байгаа, хөдөлмөр эрхэлдэггүй 975 иргэнд олгосон нь энэ зардлын 89 хувийг эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас гэр оронгүй, амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхөд нэг удаа 1.2 сая төг олгодог байна. Аймгийн 2017 онд 14 өрхөд нийт 16.8 сая төгрөгийн, 6 иргэнд нийт 14.4 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж үзүүлсэн ба холбогдох баримт бичгийг шалгуурын дагуу бүрдүүлсэн байв.

Тэтгэмжийн олголтыг шүүж давхардал байж болзошгүй 24 иргэнийг нэрсийг сонгож тулгалт хийхэд байнгын асаргаа шаардлагатай 1 иргэний асран хамгаалагчид 128.0 мянган төгрөг давхар олгосон байв.

Алдарт эхийн одонгийн тэтгэмжид 2017 онд 4810 эхэд 649.4 сая төгрөг олгосон байна. Эхийн алдар 2 дугаар зэргийн одонтой эхээс 1 дүгээр зэргийн одонтой эхийн болзол хангасан 24 хүний нэрийг шүүн гаргаж, тулгахад 2 эхэд тус бүр 100.0 мянган төгрөг илүү олгосон байна.

Иймд дээрх 3 хүнд давхардуулж олгосон мөнгийг буцаан төлүүлэхээр 328.0 мянган төгрөгийн нэг төлбөрийн акт тогтоов.

Мөн 2018 оны эхний хагас жилийн байдлаар 4749 эхэд 636.1 сая төгрөгийн алдарт эхийн одонгийн тэтгэмж үзүүлсэн. Эхийн алдар 1 дүгээр зэргийн одонтой 4 эхэд илүү мөнгө давхардуулж олгосон байсныг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар буцаан төлүүлсэн байв.

Байнгын асаргаа шаардлагатай иргэдийг асран халамжилдаг хүмүүсийн нэрсээр 2017 оны олголтыг шүүн үзэхэд Мандах, Өргөн, Улаанбадрах сумдаас бусад сумдад 24 иргэн 2 хүнийг зэрэг асарч асаргааны тэтгэмжийн мөнгө авсан байв.

Аудитаар Сайншанд сумын байнгын асаргаа шаардлагатай эмнэлгийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан 15 иргэний гэрт ХЭХАХМ-тэй хамт очиж нөхцөл байдалтай танилцахад хуулийн тавигдах шалгуурыг хангасан байв.

2.2.3 Нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу гүйцэтгэж, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн үйлчилгээ нь НХТ хуульд зааснаар дараах 2 төрлийн үйлчилгээг үзүүлнэ гэж заасан байна. Үүнд:

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2017 онд 20.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 94 хувь буюу 18.8 сая төгрөгийг зарцуулж, 1.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ. Нийт зардлын 92 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бариа засал, эмчилгээнд, 8 хувийг сэтгэл засал, зөвлөгөө өгөх үйлчилгээнд зарцуулсан байна. Харин 2018 онд 20.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, тухайн оны эхний хагас жилийн байдлаар зардал гараагүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.6-д “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэх иргэн, ААНБ-ыг сонгон шалгаруулах ажлыг аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Олон нийтийн оролцоотой халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалтыг 2016 онд ХХҮЕГ зохион байгуулж, магадлан итгэмжлэлийг ирүүлснээр 2017 онд 4 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажилласан байна. Мөн 2018 онд оролцогчдоос ирсэн материалыг ХХҮЕГ-т хүргүүлсэн байна. Иймд холбогдох журамд заасны дагуу шаардлага хангасан байгууллагыг сонгон шалгаруулсан эсэхийг нотлох боломжгүй байна.

Гэрээ байгуулан ажиллаж байгаа итгэмжлэгдсэн байгууллага нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг заасан хугацаанд ирүүлж, хянуулсан байна.

Тус байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн үйлчилгээнд явцын шалгалт хийж, эмчилгээ үйлчилгээ бүрэн бус, иргэдийн хамрагдалт нь гэрээнд зааснаас дутуу зэрэг зөрчлийг арилгуулахаар илтгэх хуудас хүргүүлж, хэрэгжилтийг тооцож, санхүүжүүлэх дүнгээс хасах арга хэмжээ авч ажилласан байна.


Нийгмийн хөгжлийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тухай хуулийн V бүлэгт нийгмийн хөгжлийн үйлчилгээнд боловсрол, эрүүл мэнд болон хүнс тэжээлийн дэмжлэг гэсэн 3 үйлчилгээг тодорхой түвшний иргэдэд үзүүлэхээр заасан байна.

Эдгээрээс боловсрол болон эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд 2017-2018 онд төсөв мөнгө зарцуулаагүй байна.

Харин хүнс тэжээлийн дэмжих үйлчилгээг үзүүлсэн байна. Уг зардалд 2017 онд 225.4 сая төгрөг, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 172.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн 2018 оны эхний хагас жилийн байдлаар уг зардалд батлагдсан төсвийн 25 хувь буюу 173.7 сая төгрөгийг зарцуулжээ.

Хүнс тэжээлийн дэмжлэгийг хүнсний бүтээгдэхүүн худалдан авах, халуун хоол цайгаар үйлчлэх гэсэн 2 хэлбэрээр олгож болох ба тус аймгийн хувьд хүнсний бүтээгдэхүүн худалдан авах хэлбэрээр хэрэгжүүлсэн байна. Сайншанд сумын иргэдэд цахим, бусад сумдад цаасан хүнсний эрхийн бичгээр үйлчилсэн байна. ХАХНХС-ын тушаалаар хүнсний эрхийн бичиг олгох босго оноо болон эрхийн бичгийн үнийн дүнг тогтоож өгсөн ба 2017 онд 240.3-292.5, эрхийн бичгийн үнэ насанд хүрсэн хүн 13000-16000, хүүхэд 6500-8000 төгрөг болж шинэчлэгдсэн байна. Харин 2018 оны журамд дахин өөрчлөлт орж босго онооны дээд хэмжээг аймагт 310.0 байхаар тогтоожээ. 2018 оны эхний хагас жилийн байдлаар ХХҮГ-ын өрхийн мэдээллийн нэгдсэн санд 13769 өрхийн мэдээлэл орсон байгаа ба дээрх судалгааны дүнгээр амьжиргааны түвшингээр 5 хуваасан байна. /Хүснэгт №4/



ӨМНС-ХЭБ дахь өрхийн түвшингийн судалгаа
/2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/

Хүснэгт №4

№	Үзүүлэлт	Үүнээс					Нийт өрхийн тоо
		1-р түвшин /доод/	2-р түвшин /харьцангуй бага хэрэглээтэй/	3-р түвшин /дундаж хэрэглээтэй/	4-р түвшин /дунджаас дээгүүр хэрэглээтэй/	5-р түвшин /илүү өндөр хэрэглээтэй/	
1	Өрхийн тоо	1249	3016	6437	2420	647	13769

Үүнээс 1-2 дугаар түвшинд байгаа буюу амьжиргааны түвшин тодорхойлох судалгаагаар босго онооны нөхцөл хангасан өрхүүдийг харьяалагдах сумдын АДЗ-өөр хэлэлцүүлэн зайлшгүй хүнс тэжээлийн дэмжлэг шаардлагатай гэж шийдвэрлэсэн өрхийг хамруулжээ.

2017-2018 онд хүнс тэжээлийн дэмжлэг авах, өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд дахин хамрагдах буюу өмнөх судалгааны дүнг хүлээн зөвшөөрөхгүй зэрэг нийт 3271 өрхөөс өргөдөл хүсэлтийг хүлээн авч өрхийн амьжиргааны түвшин тогтоох дахин судалгаанд хамруулж, сумдын АДЗ-өөр хэлэлцүүлэн шаардлагатай өрхийг нэмсэн байна.

Хүнс тэжээлийн дэмжлэгт 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 506 өрх буюу 1359 насанд хүрсэн хүн, 1478 хүүхэд хамрагджээ. /Хүснэгт №5/

**Хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдсан өрхийн судалгаа
/2018 оны эхний хагас жилийн байдлаар/**

Хүснэгт №5

№	Сумдын нэр	Өрхийн тоо	Хүний тоо
1	Айраг	21	112
2	Алтанширээ	9	51
3	Даланжаргалан	23	140
4	Дэлгэрэх	16	89
5	Замын-Үүд	48	286
6	Иххэт	30	175
7	Мандах	6	33
8	Өргөн	4	22
9	Сайншанд	283	1548
10	Сайхандулаан	8	46
11	Хатанбулаг	14	74
12	Хөвсгөл	12	68
13	Улаанбадрах	3	18
14	Эрдэнэ	22	133
15	Зүүнбаян	7	42
Нийт		506	2837

Үүнийг статистик мэдээтэй харьцуулбал аймгийн нийт өрхийн 2 хувь, нийт хүн амын 4 хувь нь энэхүү дэмжлэгт хамрагдаад байна.

Эдгээрээс түүврийн аргаар Сайншанд сумын 49 өрхийг /120 насанд хүрсэн хүн, 126 хүүхэд хамрагдсан/ аудитад хамрууллаа. Эдгээр өрх нь ӨМНС дахь ХЭБ-ийн босго оноо нь 128-309 буюу 1-2 түвшинд ангилагдсан, хувийн хэрэг дэх баримт материалыг бүрдүүлсэн, ХЭБ-ийн үнийн тооцооллыг зөв тооцсон, сумын АДЗ-өөр хэлэлцүүлсэн байна. Мөн түүвэрт хамрагдсан өрхийн амьдралын бодит байдалтай танилцсан ба олон хүүхэдтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, амьжиргааны түвшин доогуур өрхүүд байна. Эдгээр өрхүүд нь ХЭБ-ээр ихэвчлэн өргөн хэрэглээний гурил, будаа, сүү, ургамлын тос зэргийг авдаг байна.

Мөн ХАХНХС-ын 2014 оны А/32 тушаалаар батлагдсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-д аймгийн төвийн суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийг аймгийн ХХҮГ нь тухайн шатны ХАА-ны газартай хамтран сонгон шалгаруулж, гэрээ байгуулна. Харин бусад сумдад тухайн сумын Засаг дарга сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна гэж заасан байна.

Тус аймагт ХЭБ-ээр үйлчлэхээр 13 суманд тус бүр 1, Сайншанд сумын 5-р багт 1, Сайншанд суманд 3, нийт 17 дэлгүүр гэрээ байгуулан, үйл ажиллагаагаа явуулж байна.

ТБОНӨХБАУХАТ хуульд зааснаар нийлүүлэх ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс шалтгаалан ХАА-ны журмыг сонгодог. 2017 онд хүнс тэжээлийн дэмжлэгт 299.8 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсан учир ХЭБ-ээр үйлчлэх дэлгүүрийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, сонгох байсан байна.

Гэтэл аймгийн ХХҮГ нь 2017 онд Сайншанд суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийг сонгон шалгаруулахдаа аймгийн ОНӨГ-тай хамтарч ажиллаагүй, бие даан зохион байгуулжээ. Байгууллагын даргын 2017 оны А/04 дүгээр тушаалаар сонгон шалгаруулах ажлын хэсгийг томилж, ТБОНӨХБАҮХАТ хуульд заасан худалдан авах ажиллагааны журмыг баримтлаагүй, захиалагчаас тендерт оролцогчид зориулан тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон тендерийн баримт бичиг боловсруулаагүй байна. Мөн худалдан авах ажиллагааны журмын аль аргаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан нь тодорхойгүй байна. Сонгон шалгаруулалтын зарыг аймгийн FM радиогоор явуулсан ба “Сэрүүн лаврин” ХХК, “Зета од” ХХК, “Баруун дэнж” ХХК-аас оролцох хүсэлт ирүүлснээр уг дэлгүүрүүдийг шалгаруулж, гэрээ байгуулан ажиллажээ.

Харин 2018 онд аймгийн ОНӨГ-тай хамтран нээлттэй тендерийг зохион байгуулсан байна. Уг сонгон шалгаруулалтад өмнөх онд гэрээ байгуулан ажилласан дээрх компаниуд оролцох хүсэлтээ ирүүлсэн байна. Уг тендер нь 3 багцтай зарлагдсан ба “Сэрүүн лаврин” ХХК 1-р багц буюу Сайншанд сумын 4, 7-р баг, “Баруун дэнж” ХХК 2-р багц буюу 1, 2, 3, 6-р баг, “Зета од” ХХК 3-р багц буюу 1, 2, 3, 6-р багт үйлчлэхээр шалгарсан байна. Эдгээрээс “Сэрүүн лаврин” ХХК, “Зета од” ХХК нь 8 нэрийн хүсний дэлгүүр байна. /Зураг №3-5/

Зураг №3



Зураг №4



Зураг №5



Мөн ХЭБ-ээр үйлчлэхээр шалгарсан дэлгүүрүүд нь иргэдэд 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх ба уг худалдан авалтын тайланг аймгийн ХХҮГ-т сар бүр ирүүлнэ гэж журамласан байна. Үүний дагуу сумдад шалгарсан дэлгүүрүүд сар бүр сумын нийгмийн ажилтантай тооцоо нийлсэн байна. Харин Сайншанд сум дахь 3 дэлгүүр аймгийн ХХҮГ-т худалдан авалтын тайланг ирүүлжээ. Уг дэлгүүрүүдээс ирсэн тайланг үзэхэд иргэдийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бүртгэлийг хөтөлсөн боловч зарим зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- Хүнсний бүтээгдэхүүнийг нэр төрөл тус бүрээр бичээгүй, нийт үнийн дүнгээр бүртгэсэн. Энэ нь журамд заасан 10 нэр төрлийн бүтээгдэхүүн авсан эсэхийг хянах боломжгүй байна.
- Худалдан авалтыг 2 талаас гарын үсэг зурж баталгаажуулаагүй.
- Бүтээгдэхүүний бүртгэлээрх үнийн дүн нь тооцооны баримтын /кассын/ дүнгээс зөрүүтэй зэрэг зөрчлүүд байна.

ХЭБ-ээр үйлчилж байгаа дээрх дэлгүүрүүд махнаас бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг борлуулдаг ба хүнсний эрхийн бичгийн олголтын үеэр захиалсан нөхцөлд мах авчирдаг гэсэн тайлбарыг өгч байв.

Мөн ХЭБ-ээр олгох 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг тогтмол үнийн дүнгээр нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна. Нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалтыг дэлгүүрт байршуулсан боловч бүтээгдэхүүн бүрийн үнийг мэдээлээгүй нь тухайн бүтээгдэхүүн үнэ ханш сар бүр хэрхэн өөрчлөгдөж, худалдаалагдаж байгааг иргэд хянах боломжгүй байна. Мөн Сайншанд суманд үйлчилж байгаа дээрх дэлгүүрүүд нь цахим эрхийн бичгээр үйлчилдэг ба “Төрийн банк”-ны пос машиныг гэрээнд заасны дагуу үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Иймд үнийн өөрчлөлт байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор бүтээгдэхүүн тус бүрийн үнийг дэлгүүрүүд мэдээллийн самбарт мэдээлэх, дэмжлэг авдаг иргэдэд танилцуулах тухай зөвлөмжийг аймгийн ХХҮГ-н удирдлагад зөвлөмжөөр хүргүүлэхээр шийдвэрлэв.

Харин бусад сумдад 2017-2018 онд аймгийн ХХҮГ нь ХЭБ-ээр үйлчлэх дэлгүүрийг сумдын АДЗ-өөр хэлэлцүүлэх нь тохиромжтой гэсэн чиглэл өгснөөр Сайншанд сумаас бусад сумд АДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн сонгон шалгаруулсан байна.

Мөн ХЭБ-ийн олголт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүргийг мэргэжлийн хяналтын байгууллага болон байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж хариуцна гэж “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-д заасан байна.

Гэтэл 2017 онд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй, 2018 оны төлөвлөгөөнд хяналт хийхээр төлөвлөсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Үүний дагуу ХЭБ-ийн олголт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах тухай зөвлөмжийг тус байгууллагын удирдлагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.4 Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийг хуульд заасан хугацааг баримтлан олгосон хэдий ч хувь хэмжээг нягтлах нь зүйтэй байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн 26 дугаар зүйлд нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд 16 төрлийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлнэ гэж заасан байна. Уг үйлчилгээнд 2017 онд 303.4 сая төгрөг батлагдсанаас 171.5 сая зарцуулж, 132.0 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Харин 2018 онд 296.0 сая төгрөг батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 31.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь батлагдсан төсвийн 10.7 хувийг эзэлж байна. /Хүснэгт №6/

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтөд зарцуулсан зардал

Хүснэгт №6

№	Хөнгөлөлт үйлчилгээний төрөл	2017 он		2018 он	
		Хүний тоо	Зарцуулсан хөрөнгийн дүн /сая.төг/	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгийн дүн /сая.төг/
1	ХБИ-д олгосон түлшний үнэ	608	88.1	13	1.8
2	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон протез, ортопед, тэргэнцэр болон тусгай хэрэгслийн зардал	134	37.8	56	8.2
3	ХБ хүүхдийг асрамжилж яваа иргэний унааны зардал	2	0.2	-	-
4	Дотоодын рашаан сувилалд сувилуулсан зардал	87	16.1	23	6.3
5	Насанд хүрсэн бүрэн хараагүй хүнд харилцаа, холбооны зардал	90	16.5	84	8.8
6	ХБИ оршуулгын зардал	13	12.8	6	6.0
Нийт дүн		934	171.5	182	31.1

Харин “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль” /2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчингүй болсон/-д ахмад настанд 5 төрлийн, “Ахмад настны тухай хууль”-д 6 төрлийн дэмжлэгийг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр заасан байна. Нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлсэн ахмад настанд дэмжлэг үзүүлэх зардалд 2017 онд 253.9 сая төгрөг батлагдсанаас 404.8 сая төгрөг зарцуулж 150.1 сая төгрөгөөр төсөв хэтэрсэн байв.

2018 онд 315.0 сая төгрөг батлагдаж эхний хагас жилийн байдлаар 105.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. /Хүснэгт №7/

Ахмад настанд үзүүлэх дэмжлэгт зарцуулсан зардал

Хүснэгт №7

№	Хөнгөлөлт үйлчилгээний төрөл	2017 он		2018 он	
		Хүний тоо	Зарцуулсан хөрөнгийн дүн /сая.төг/	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгийн дүн /сая.төг/
1	Хөл, гар, шүд /үнэт металлаас хийхээс бусад/-ын сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, дотоодод хийлгэсэн зардал	651	138.6	266	35.0
2	Амралт сувилаллын зардал	1194	184.2	202	39.5
3	Хүндэт донор, тэжээн тэтгэх үр хүүхэдгүй эсвэл хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд ахмад настанд олгосон орон сууцны хөлсний хөлс, түлшний үнэ	130	19.8	6	0.8
4	Ахмад настны оршуулгын зардал	4	3.8	-	-
5	Харьяалалгүй ахмадад хүндэтгэл үзүүлэх	2954	58.4	3025	30.2
Нийт дүн		4933	404.8	3499	105.5

Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамжийн сангаас зарцуулсан нийт зардлыг 2017-2018 оны эхний байдлаарх дүнг нэгтгэн хянахад давхардуулан олгосон зөрчилгүй, хуульд заасан олгох хугацааг баримталсан байна.

Мөн ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлттэй үнээр амарч, сувилуулсан газар нь сонгон шалгаруулалтад тэнцэж нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан газар байхаар хуульчилсан байна. Үүний дагуу ХХҮЕГ-аас ирүүлсэн амралт, сувиллын газрын жагсаалтыг 2017-2018 онд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлттэй үнээр амарч сувилуулсан газартай тулгахад зөрүүгүй байна.

Харин тогтоосон хувь хэмжээгээр олгосон эсэхийг түүвэрлэн хянаж үзэхэд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн 26.1.7в-д “ ... хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дотоодын рашаан сувилалд сувилуулбал унаа, ор хоногийн зардлыг энгийн өрөөний тарифаар тооцож 50 хувиар олгоно” гэж заасныг зөрчиж, хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэнд 2017 оны 08 дугаар сард 206.3 мянган төгрөг олгохоос 394.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь хуулиар тогтоосон хэмжээнээс 187.7 мянган төгрөгөөр илүү байна. Энэ зөрчилд илүү олгосон дүнгээр байгууллагын удирдлага, холбогдох мэргэжилтэнд хариуцуулан төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
САНД ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

БҮЛЭГ 3

**Хяналтаар өгөгдсөн зөвлөмжийг үйл
ажиллагаандаа үр нөлөөтэй хэрэгжүүлэх
шаардлагатай байна.**

3.1 Халамжийн сангийн үйл ажиллагаанд хийгдсэн хөндлөнгийн болон дотоод хяналтын зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

3.1.1 Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар үйл ажиллагаандаа тусгасан боловч зөрчил гарсаар байгааг аудитын дүн харуулж байна.

Нийгмийн халамжийн тухай хууль болон Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын байгууллага хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Аймгийн МХГ-аас 2017 онд нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр тэтгэмж, хөдөлмөр эрхлэлтийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг байдалд 2015-2016 оныг хамруулан хяналт шалгалт хийжээ. Уг шалгалтаар сангийн орлого, зарлагад дүн шинжилгээ хийж, нийгмийн халамжаас олгох тэтгэврийн үйл ажиллагааг шалгасан байна.

Шалгалтаар иргэдийн хувийн хэрэг эмх цэгцгүй, анхан шатны баримт бүрдэл дутуу, тэтгэвэр тэтгэмжид хамрагсдыг амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, орлого бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод хяналтыг төлөвлөж, үр дүнг тооцоогүй, тэтгэвэр тэтгэмжийг олгохдоо хяналт тавьж ажиллаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Мөн цаашид хэрэгжүүлэхээр ХХҮЕГ-т 1, аймгийн ХХҮГ-т 2 саналыг хүргүүлжээ.

Мөн ХАХНХ-ын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-д “ХЭБ-ийн олголт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих үүргийг мэргэжлийн хяналтын байгууллага болон байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж хариуцна” гэж заасан байна. Аймгийн МХГ-аас 2017-2018 онд ХЭБ-ийн олголт, хөрөнгийн зарцуулалтад шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тус байгууллагад хяналт шалгалт хийж холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн ба 2017 оны 09 дүгээр сард хэрэгжилтийг үнэлэх дахин шалгалтыг зохион байгуулсан байна. Уг шалгалт нь байгууллагын ажлын зохион байгуулалт, хүний нөөц, байгууллагаас нэвтрүүлсэн бүтээлч санаа зэрэгт чиглэгдсэн байна. Цаашид хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалттай холбоотой 9 зөвлөмжийг хүргүүлжээ.

Аудитаар илэрсэн зөрчлөөс /тайлангийн 2 дугаар бүлгийн хэсэг/ үзэхэд хөндлөнгийн шалгалтын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Хяналт, шинжилгээ үнэлгээний нэгжийн төлөвлөсөн зарим ажлууд хийгдээгүй, хугацааг тодорхой бус тусгасан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24.8-д нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь НХҮ-ний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина гэж заасан байна.

ХХҮЕГ-аас 2017 оны 10 дугаар сард халамжийн сангийн үйл ажиллагаа, санхүүгийн баримтад шалгалт хийж халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой зөрчлүүдэд дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Хөнгөлөлт тусламж олгохдоо өргөдлийн утга агуулга, бусад баримт материалыг сайтар нягталж байх;
2. Ахмад настанд ортопедийн хэрэгсэл олгохдоо журамд байгаа эсэхийг нягтлах;
3. Рашаан сувилалд амарсны төлбөрийг хянаж олгох гэсэн зөвлөмжийг өгсөн байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9-д “... аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хяналт шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг хэрэгжүүлэх ажилтантай байна” гэж заасны дагуу тус байгууллагад уг чиг үүрэг бүхий орон тооны 2 мэргэжилтэн ажиллаж байна.

Аймгийн ХХҮГ нь жил бүр “Эрсдэл, хяналт шалгалтын төлөвлөгөө” боловсруулан баталж, төлөвлөгөөний дагуу тухай бүр хяналт шалгалтын удирдамжийг боловсруулан ажиллажээ. Хэдийгээр дээрх төлөвлөгөөг боловсруулан баталсан боловч зарим төлөвлөсөн хяналтыг 2018 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлээгүй, хийж гүйцэтгэх хугацааг тодорхой тусгаагүй байна. Тухайлбал:

- ХЭБ-ээр үйлчилдэг дэлгүүрүүдэд төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтыг хийж гүйцэтгэх /хугацаа-жилийн турш/;
- АДЗ-ийн гишүүдийг мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг хийж гүйцэтгэх. /хугацаа-жилийн турш/ гэх мэт.

Сумдын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, өдөрлөг зохион байгуулахаар 2017 он болон 2018 оны 1-2 улиралд байгууллагын даргын батлагдсан удирдамжийн дагуу ажлын хэсэг нийт сумдаар тойрч, ажилласан байна. Энэхүү тойролтоор нийгмийн халамжийн сантай холбоотойгоор өмнөх оны хяналт шалгалтын үр дүнгээр хийж гүйцэтгэсэн ажлын хэрэгжилтийг тооцож, сумдын удирдлага, иргэдэд үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулгыг хийсэн байна.

Мөн сумдын халамжийн үйлчилгээ, хөнгөлөлт, дэмжлэгт хамрагдаж байгаа иргэний хувийн хэрэгт үзлэг шалгалт хийж, зөрчил арилгах зөвлөмж өгч, зарим иргэдтэй уулзаж, тэмдэглэл хөтөлжээ.

Мөн халамжийн үйлчилгээ, үйл ажиллагаа, ажилтан алба хаагчидтай холбоотой өргөдөл, гомдлын дагуу хяналт шалгалт хийж, илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулж шийдвэрлэн, холбогдох мэргэжилтэнд мэдэгдлээр хүргүүлсэн байна.

3.2. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

3.2.1 Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.


Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу хангах тус байгууллагаас дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна Үүнд:

- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тус байгууллагын “Мэдээллийн самбар”-т байршуулан, тухай бүр шинэчлэн байршуулсан байна. Мөн байгууллагаас иргэд, олон нийтэд танилцуулах гарын авлага, зурагт хуудсууд хэвлэн тараан байршуулсан байна. Үүний зэрэгцээ байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн телевизээр мэдээллийг хүргэсэн байна.
- Олон нийтийн сүлжээнд иргэдийг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын цахим сайт болон Facebook хуудсаар дамжуулан өдөр тутмын үйл ажиллагаа болон бусад мэдээ тайланг мэдээлсэн байна.

Зураг №6



Зураг №7



- Мөн аймгийн хэмжээнд жил бүр “Хөдөлмөр-222” өдөрлөгийн зохион байгуулж хэвшсэн байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөг болгон зохион байгуулдаг ба сум бүрийн хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн зохион байгуулсан ажлын талаарх зурагт тайланг аймгийн ХХҮГ-т ирүүлсэн байна.
- ХЭБ-ээр үйлчилдэг дэлгүүр болон уг халамжийн үйлчилгээнд шинээр хамрагдсан иргэдэд “Зөв харилцаа-соёлтой үйлчилгээ” сэдвээр сургалтыг зохион байгуулсан байна.

3.2.2 Шилэн дансны тухай хуулийн зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх зорилгоор аудитын дүгнэлт, төсвийн сар улирлын мэдээг байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт байршуулсан байна.

Харин “Шилэн дансны нэгдсэн систем” дэх тус байгууллагын цахим хуудсыг шалгахад дараах мэдээллийг мэдээлээгүй зөрчил байна. Үүнд:

- 2017 онд дараа оны төсвийн төслийг мэдээлээгүй;
- 2017 оны 1, 9, 10, 11, 12-р саруудын төсвийн гүйцэтгэлийн мэдээ мэдээлээгүй;
- 2017-2018 онд 5 саяас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /орлогын 4,076.3 сая төгрөгийн 76 гүйлгээ, зарлагын 2,994.1 сая төгрөгийн 48 гүйлгээ/;
- 2017 оны санхүүгийн тайлан бүтэн жилээр мэдээлээгүй;
- 2017, 2018 оны аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан байршуулаагүй зэрэг зөрчил илэрч байна.

Хэдийгээр тус байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтнүүд уг хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалт хийсэн боловч зөрчил дахин давтан гарсаар байна.

Иймд дээрх зөрчилд “Шилэн дансны тухай хууль”-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн мэргэжилтнийг мэргэшүүлэн чадваржуулах, амьжиргаа дэмжих зөвлөлийг арга зүйгээр хангаж ажиллах хэрэгтэй байна.
- Өрхийн мэдээллийн сангийн мэдээллийн үнэн зөв байдалд анхаарч ажиллаагүй байна.
- Төсвийн зарим зардлуудыг судалгаа болон бодит гүйцэтгэлд үндэслэн тооцоогүй, нөхцөл байдлыг зөв үнэлж төлөвлөөгүй байна.
- Тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтад тавих хяналт дутагдсанаас алдарт эхийн одонгийн мөнгө, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд амралт, сувилуулсны хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.
- Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаанд зохих шатны хяналт шалгалт хийгддэг ч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Хүнсний эрхийн бичгийн олголт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Шилэн дансны тухай хуульд заасан зарим мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлээгүй байна.

Аудитаар нийт 7,070.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 515.1 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож 7,070.4 сая төгрөгийн зөрчилд холбогдох зөвлөмжийг хүргүүллээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

1. Мэргэжилтнүүдийг халамжийн үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;
2. Амьжиргаа дэмжих зөвлөлийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;
3. Өрхийн мэдээллийн санд баталгаажсан үнэн зөв мэдээллийг оруулж ажиллах;
4. Халамжийн сангийн хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөх, зарцуулалтад тавих шат шатны хяналтыг хэрэгжүүлэх;
5. Шилэн дансны нэгдсэн системд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**ДОРНОГОВЬ АЙМАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайтшанд сум,
Утас/факс: (705) 2-23-92

2018.09.28 № 314

танай 2018.09.24-ны № 1-6/543 -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Тус газраас “Орон нутгийн төсвийн нийгмийн халамжийн санд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангай холбоотой саналыг хүргүүлэв.

Хавсралт .../ хуудастай.

ДАРГА



Д.ЦЭНДМАА

0000722

**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНД ОЛГОСОН
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ДҮГНЭЛТЭД ТУСГАХ САНАЛ**

БҮЛЭГ 1.1.3 ЗААЛТЫН ХҮРЭЭНД

Тус газрын зүгээс 2017 оны 01 дүгээр сард зохион байгуулсан удирдах ажилтны аймгийн зөвлөгөөнд /Сумдын засаг дарга, орлогч дарга тамгын дарга нар хамрагдсан/ хөдөлмөр халамжийн чиглэлээр мэдээлэл хүргэж, сумдын амьжиргааг дэмжих зөвлөл ажиллах журмыг танилцуулсан.

Мөн 2017 онд бүх сумдад дотоод хяналт шалгалтаар ажиллахдаа АДЗ-н хурлын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцаж хяналт шалгалтын илтгэх хуудсанд тэмдэглэл хийж чиглэл өгч ажилласан.

ХХҮГазрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/05 дугаар тушаалаар “НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЕЧИЛСЭН ХЯНАЛТ ХИЙХ ЖУРАМ” баталсан. Уг журмын дагуу сумдын АДЗ-ийн үйл ажиллагаанд чиглэл өгч, нөхцөл байдлын үнэлгээ хийх хүснэгт, зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулан хүргүүлсэн.

2017 онд АДЗ-н гишүүдэд улирал бүр урамшуулал олгохдоо хуралд суусан ирцийн дагуу бодож олгосон. 2018 онд ХХҮГ-н даргын 2018 оны А/05 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу АДЗ-н улирлын ажлын тайланг дүгнэж үнэлсэн үнэлгээ, хуралд суусан ирцийн бүртгэл, тайлан ирүүлсэн хугацааг харгалзан 1, 2 дугаар улирлын урамшуулал олгосон.

2018 оны эрсдэл, хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрийн хооронд бүх сумдад хяналт шалгалтаар ажиллаж, ХХҮГ-ын дарга иргэдтэй уулзалт хийж, 2017 оны ХХҮГ-ын үйл ажиллагааны тайлан, 2018 онд хэрэгжих төсөл хөтөлбөрийг танилцуулж ажилласан. Мөн сумдын АДЗ-н гишүүд, сумын Засаг дарга нарт АДЗ-н ажиллах журам, ХХҮГ-н даргын 2018 оны А/05 дугаар тушаалаар батлагдсан “АДЗ-г үнэлж дүгнэх журмыг танилцуулж, гарч буй алдаа дутагдал, цаашид анхаарч ажиллах зарим нэг зүйл залтын талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан. Батлагдсан журмын дагуу АДЗ-н гишүүд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж байгаа иргэдэд нөхцөл байдлын үнэлгээг ХХҮГ-аас гарсан загвар хуудсаар үнэлж хурлаар хэлэлцэх болсон.

БҮЛЭГ 1.2.3 ЗААЛТЫН ХҮРЭЭНД

Тус газар нь 2016 оны 11 сараас эхлэн төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлэх, мэдээлэл өгөх зорилгоор сар бүрийн 2 дахь 7 хоногийн 2 өдрийн 14 цагт “Хөдөлмөр, халамж – 222” өдөрлөг арга хэмжээг тогтмол явуулж ирсэн. 2018 оны эхний хагас жилийн байдлаар Сайншанд сумын 1-7 дугаар багт болон 13 сумдад уг арга хэмжээг зохион байгуулж хөдөлмөр эрхлэлтийн болон

нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн талаар мэдээлэл хүргэж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч ажилласан.

Энэ үеэр арга хэмжээнд оролцсон иргэдээс тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн гарын авлага бэлтгэсэн. Уг судалгаагаар гарсан саналыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахаар мэргэжилтнүүдэд үүрэг болгоод байна.

ТАНИЛЦСАН:

ДАРГА

Д.ЦЭНДМАА

БОЛОВСРУУЛСАН:

НХХ-Н ДАРГА

Б.МӨНХДАВАА

ХШҮХМ

Н.ХОНГОРЗУЛ

САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Санал 1: Аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын ирүүлсэн саналын 1.1.3-т тусгуулах саналын хүрээнд АДЗ-ийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар ирүүлсэн байна.

Тайлбар 1: ХХҮГ-ын даргын “Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгох журам” нь 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан ба энэ нь 2017 оны ажилд хамаарахгүй байна. Мөн 2018 оны АДЗ-тэй холбоотой баримтад сумдаас ирүүлсэн ажлын тайлан, хурлын тэмдэглэл байгаа ба ажлын тайланг хэрхэн үнэлж дүгнэсэн үнэлгээний баримт материал аудитын явцад ирүүлээгүй болно. Иймд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Санал 2: Тус байгууллага нь “Хөдөлмөр -222” өдөрлөгийг тогтмол зохион байгуулдаг.

Тайлбар 2: “Орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн санд олгосон хөрөнгийн зарцуулалт , үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн III бүлгийн 2 дахь хэсэгт дээрх үйл ажиллагааны талаар бичигдсэн. Иймд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2018 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/20

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.2, Ерөнхий аудитын 2017 оны А/188 тоот тушаалын V хавсралт, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 он аудитын төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн санд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, төлбөрийн актыг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргад зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

9825955